



ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН

Аудитын нэр: 2022 оны худалдан авалтын төлөвлөгөө, гүйцэтгэл, БМ-ын хүлээн авалт гарч буй хүндрэл.

Аудитад хамаарах нэгжүүд: ИАлба, ХААХэлтэс, СЭЗХэлтэс, бусад холбогдох албан тушаалтнууд

Огноо: 2022 оны 12 сар 28

АУДИТЫН ХУГАЦАА:

Дуусах хугацаа 2022.12.28

Аудит хийх үндэслэл:

Дотоод аудиторын жилийн ажлын төлөвлөөгөөний дагуу гүйцэтгэх захирлаар батлуулсан хөтөлбөрийн хүрээнд хийнэ.

Аудитын зорилго:

Компанийн 2022 оны худалдан авах ажиллагаанд дотоод хяналт шалгалт хийж зөвлөмж гарган гүйцэтгэх удирдлагад танилцуулах, гарсан алдаа зөрчлийг арилгахад оршино.

Хамрах хүрээ:

2022 оны худалдан авах ажиллагааны дотоод хяналтын тайланг 6 чиглэлд хийж гүйцэтгэхээр төлөвлөгөө гаргасан. Үүнд:

- Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хүлээн авах
- Нээлттэй тендер шалгаруулалт
- Харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн тендер шалгаруулалт
- Шууд худалдан авалт
- Өмнөх онуудаас дамжин ирсэн ажлуудын гүйцэтгэл
- 2022 оноос дараа онд шилжиж буй ажлууд

4. Аудитын арга зүй, стандартын мэдэгдэл:

Холбогдох ажилтантай ярилцах, тайлбар тодруулга авах, худалдан авах ажиллагааны материалд шинжилгээ хийх, анхан шатны баримт материалыг шалгах, тулган баталгаажуулах зэрэг арга зүй ашиглан цуглуулсан нотлох баримтад дүн шинжилгээ хийж дотоод аудитын дүнг боловсруулж, түүнд үндэслэн дүгнэлт зөвлөмж өглөө.

Аж ахуй нэгж байгуулагын үйл ажиллагаанд дотоод хяналт явуулах зохион байгуулах нийтлэг журам, ЭДЦС" ТӨХК-ийн дотоод хяналт шалгалт хийх журмын дагуу аудитын дүн дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, ажлын баримтыг хавсаргав.

5. Аудитын шалгуур үзүүлэлтийн харьцаа

Аудит хийхэд дараах хууль эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд

- ТБОНӨХБАҮХАТХууль
- Байгууллагын хэмжээнд мөрдөгдөж буй дүрэм, журам
- Гүйцэтгэх захирлын тушаал
- Шилэн дансны тухай хууль
- Холбогдох бусад хууль тогтоомж

Нөхцөл байдал:

1. Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах, хүлээн авах

2022 онд мөрдөх худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг 2022 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр нээлттэй тендер шалгаруулалтын 33 нэр төрлийн худалдан авалтанд 8,451.2 сая төгрөгийг, харьцуулалтын аргаар худалдан авалт хийх 28 нэр төрлийн худалдан авалтанд 1,261.3 сая төгрөг, шууд гэрээ байгуулах, шууд худалдан авалт хийх 52 нэр төрлийн худалдан авалтанд 413.13 сая төгрөгийг, нийт 113 нэр төрлийн худалдан авалтанд 10,125.7 сая төгрөгийг батлуулан мөрдөж ажилласан байна.

ЭХЯамнаас өгсөн чиглэлийн дагуу худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд 2 удаа тодотгол хийдсэн байна.

Эхний тодотгосон төлөвлөгөө 2022 оны 06-р сарын 10-ны өдөр батлагдсан бөгөөд тухайн онд тэвчиж болох 6 төрлийн 496.1 сая төгрөгийн худалдан авалтыг хассан, мөн анхны батлагдсан төлөвлөөний дүн тендер шалгаруулалтаар байгуулсан гэрээний дүнгийн зөрүүнээс 323.8 сая төгрөг хэмнэгдсэн байна.

Худалдан авалт хасагдсан боловч үйлдвэрлэлийн явцад зайлшгүй шаардлагтай 31 төрлийн худалдан авалтад 740.04 сая төгрөгийг нэмж батлуулсан байна.

Тодотгосон төлөвлөгөөг анхны төлөвлөгөөнөөс 74.9 сая төгрөгөөр бууруулан батлуулсан байна.

Эцсийн тодотгосон төлөвлөгөө 2022 оны 09 дүгээр сарын 27-ны өдөр батлагдсан бөгөөд тэвчиж болох 16 төрлийн 264.4 сая төгрөгийн худалдан авалтыг хассан байна.

Худалдан авалт хасагдсан боловч үйлдвэрлэлийн явцад зайлшгүй шаардлагтай 15 төрлийн худалдан авалтанд 357.6 сая төгрөгийг нэмж батлуулсан.

Өмнөх тодотгосон төлөвлөгөөнөөс 93.2 сая төгрөг нэмэгдэж батлагдсан байна.

/Дэлгэрэнгүй ажлын баримтыг хавсралт №1-р харуулав./

ХААХэлтэс тухайн оны 12-р сарын 15-ны дотор ЭХЯаманд худалдан авах ажиллагааны тайланг хүргүүлэн ажилласан байна.

Их засвар, ТЗБАХ, хөрөнгө оруулалт, урсгал зардлын сэлбэг материалыг хүлээн авах ажил хангалтгүй байна.

Чиг үүргийн хүрээнд ИАлбанд байх техник хяналтын инженерүүд Их засварын, ТЗБАХ-ын ажилд хяналт тавьж байна. Хяналтыг гүйцэтгэх захирлын 2022 оны 02 дугаар сарын 22-ны өдрийн А/49 тоот “Үндсэн ба туслах тоноглолын их засвар, Техник зохион байгуулалтын арга хэмжээгээр хийгдэх ажилд хяналт тавих журам”-ын дагуу гүйцэтгэж байна. Батлагдсан ажлын дагуу тендер зарлан гэрээ байгуулан, гэрээт ажилд шаардлагатай материалыг авчирсан үед ДХХ-ын хяналтын инженер, ИА-ны техник хяналтын инженер, харьяа цехийн инженер техникийн ажилнууд тус материалыг станцад орохоос өмнө техникийн тодорхойлолтод заагдсан тоо ширхэг, марк, үзүүлэлтийг тулгаж үзэн шалгадаг. Шаардлага хангасан материалыг “ЭДЦС”ТӨХК-д гаднын байгууллагын сэлбэг бараа материал оруулсан бүртгэлийн журнал”-д бүртгэн нэвтрүүлдэг. Хяналтын инженерүүд сэлбэг материалыг хүлээн авсан, хүлээлгэн өгсөн баримт бүрдүүлж гаднын байгууллагын ажилтнаар гарын үсэг зуруулж хүлээлцдэг байна.

Засварын сэлбэг материалыг өдөр тутмын хяналтаар үзэж шалгадаг ба 7 хоногт 1 удаа ажлын явцын протокол бичсэн байна.

Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу болон бусад худалдан авч буй бараа, сэлбэг материалд хяналт тавьж, хүлээн авах албан тушаалтнууд тодорхойгүй байх бөгөөд чанарын шаардлага хангасан бараа материал нийлүүлэгдэж байгаа эсэхийг хянах боломж бага байна. ДХХэлтэст бараа материал хүлээн авах ажилд хяналт тавих орон тооны хяналтын инженер байхгүй байна.

Хүлээн авах ажлыг үүрэгжүүлсэн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй журам байхгүй байна.

2021 оны 07-р сарын 28-ны өдрийн А/72 тоот тушаалаар 2021 оны худалдан авсан бараа материалын хэрхэн хүлээн авах тухай заасан 2022 онд үйлчлэх боломжгүй байна.

2022 онд нийлүүлэгдсэн бараа материалд ХААХэлтэсийн дарга, СЭЗХэлтсийн нярав, тухайн цехийн инженер зөвхөн тоо хэмжээний хувьд хүлээн авч байгаа бөгөөд чанар байдалд хяналтын инженер хяналт тавьж хүлээн авахгүй байна. Иймд 2023 оны худалдан авалтаар нийлүүдэгдэж буй бараа материалыг хэрхэн хүлээн авах талаар журам боловсруулж гүйцэтгэх захирлаар батлуулан ажиллах шаардлагтай байна. Бараа материал хүлээн авах комисст ХААХ, ДХХэлтэс, СЭЗХэлтэс, ИАлба, тухайн материалыг ашиглагч цехээс төлөөлийг оролцуулах нь зүйтэй байна.

- ✦ Худалдан авах ажиллагаагаар нийлүүлэгдэж буй бараа материалыг хүлээн авах комиссыг байгуулж албан тушаалтнуудыг үүрэгжүүлэх.
- ✦ Тодотгол бүрт нэмэгдэж буй худалдан авалтууд ихэвчлэн насжилт өндөр болсон үндсэн тоноглолд гэнэтийн техникийн гэмтэл гарсан тул үндэслэлтэй байна.

2. Нээлттэй тендер шалгаруулалт:

Эцсийн тодогтосон төлөвлөгөөгөөр 33 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээг нээлттэй тендер шалгаруулалтаар худалдан авхаар төлөвлөсөн байна.

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 47-р зүйлд заасны дагуу нээлттэй тендер шалгаруулалт бүрт үнэлгээний хороо байгуулж гишүүн бүр АЗ гэрчилгээ авсан байна.

Дээрх худалдан авалтаас 28 төрлийн бараа, ажил үйлчилгээ худалдан авалт ондоо бүрэн дуусч гэрээ дүгнэгдсэн, 5 төрлийн бараа, ажил үйлчилгээ дуусаагүй он дамжиж байна.

Байгуулагдсан үнэлгээний хороо 33 нэр төлийн бараа ажил үйлчилгээг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер шалгаруулалтын үйл ажиллагааг 1-5 удаа зарлан зохион байгуулсан бөгөөд оролцогч оролцоогүй, шаардлага хангаагүй үндэслэлээр 5 ажилд гэрээ шууд байгуулсан байна.

Он дамжин хийгдэж буй бараа, ажил үйлчилгээ:

№	Он дамжсан ажлуудын нэр	Ажил эхэлсэн он	Гүйцэтгэгч байгууллага	Мөнгөн дүн /мян.төг/	тайлбар
1	Зуух №3-т их засвар хийх	2022	СММ ХХК	2,100,000.0	2022 онд хийгдэх ажил дууссан. 2023 онд үргэлжлүүлэн үлдсэн ажил хийгдэх болно. Гүйцэтгэл 50 хувьтай
2	Цахилгаан хөдөлгүүр 4АМ-355М-6У3 /200 кВт/, Цахилгаан хөдөлгүүр 4А355М8У3 /160 кВт/, Цахилгаан хөдөлгүүр 4А3М-500/6000 УХЛА тус тус нийлүүлэх.	2022	"Бүж нар" ХХК	199,500.0	2 хөдөлгүүр нийлүүлэгдсэн. 1 хөдөлгүүр нийлүүлэгдээгүй байна.
3	Өөрөө буулгагч авто машин /Hyundai HD270 Dump Truck/ нийлүүлэх	2022	"Хьюндай Моторс монгол"ХХК	345,000.0	БНСУ-ын хэмжээнд ачаа ачилтын тээврийн салбарын

					ажилчид бүрэн ажил хаялт зарласны улмаас үйлдвэрийн процесс бүрэн зогссон. 03 дугаар сарын 01-ний өдрөөс өмнө нийлүүлнэ гэсэн тайлбар өгсөн.
4	Ган труба нийлүүлэх	2022	"Тано Эрдэнэ" ХХК	114,200.0	38,000.0 мянган төгрөгийн труба хоолойг нийлүүлсэн. Үлдсэн хоолойг оны дараа нийлүүлнэ.
5	Зуух №3, 4-ийн модуль контроллер, программ хангамжийн шинэчилэлд шаардлагатай материал нийлүүлэх	2022	'Хэрлэнгийн боргио" ХХК	72,796.0	Гэрээний хугацаа 2023 оны 01 дүгээр сарын 14 өдөр дуусна.

✚ Он дамжин хийгдэж буй ажлуудын гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгүүлэх.

3. Харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн тендер шалгаруулалт:

Тодотгосон төлөвлөгөөгөөр харьцуулалтын аргаар 22 нэр төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авхаар батлуулсан байна. Харьцуулалтын аргаар бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа 3 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсгийг гүйцэтгэх захирлын тушаалаар томилон ажиллуулж байна. ТБОНӨХБАҮХАТХуулийн 47.1 "Бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртөг энэ хуулийн 8.1.1-д заасан дээд хязгаараас давсан тохиолдолд захиалагч үнэлгээний хороо байгуулна"-т заасантай нийцэж байна. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллаж буй ажилчид АЗ гэрчилгээ авсан байна.

Харьцуулалтын аргаар гүйцэтгэсэн бараа ажил үйлчилгээний 21 ажил ондоо багтан бүрэн хийгдэж гэрээ дүгнэгдсэн, гэрээний хугацаа дуусаагүй 1 ажил байна. Ажилчдад олгож буй хор саармагжуулах бүтээгдэхүүнийг "Эрдэнэт ХААН СҮҮ"ХХК нийлүүлж байгаа бөгөөд гэрээний хугацаа 2023 онд дуусна.

✚ Нийлүүлэлттэй холбоотой гарсан зөрчил байхгүй.

4. Шууд гэрээ байгуулах

Шууд гэрээ байгуулах 11 төрлийн бараа ажил үйлчилгээг төлөвлөгөөнд тусган батлуулан ажилласан байна.

11 төрлийн бараа ажил үйлчилгээнээс 4 төрлийн бараа ажил үйлчилгээний төсөвт өртөг 3Газраас тогтоосон босго үнээс давсан байна.

ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8-р зүйл, МУ-ын ЗГазрын 2021 оны 05-р сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолд заасны дагуу шууд худалдан авч болох бараа ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоосон байдаг.

Босго үнээс давсан 4 төрлийн шууд худалдан авалтаас гэрэлтүүлгийн ламп, дагалдах хэрэгсэлийн худалдан авалт хуульд нийцэж байна.

Дэлгэрэнгүймэдээллийг хүснэгтээр харуулав.

№	Нэр	Төрөл	Батлагдсан мөнгөн дүн /мян.төг/	Тухайн онд санхүүжүүлэх мөнгөн дүн /мян.төг/	Тайлбар
1	Эрчим хүчний аудит хийлгэх	Ажил	20,000.0	20,000.0	ЗГ-ын тогтоолтой нийцэж байна.
2	Гэрэлтүүлгийн ламп, дагалдах хэрэгсэл	Ажил	30,114.0	30,114.0	Орхон аймагт үйл ажиллагаа явуулдаг "Анд энерги"ХХК 2020.10.28-ны өдрөөс 2030.05.04 хүртэл оюуны өмчийн гэрчилгээ эзэмшиж байгаа тул ТБОНӨХБӨҮХАТХуулийн 34.1.2-т зааснаар шууд гэрээ байгуулах үндэслэлтэй байна.
3	Бүрэн автомат угаалгын машин /25-30кг/ нийлүүлэх	Бараа	19,900.0	19,900.0	ЗГ-ын тогтоолтой нийцэж байна.
4	Өрөөний дотор агаарыг хөргөх зориулалт бүхий кондейшн /1.5 Hp/ нийлүүлэх	Бараа	12,000.0	12,000.0	ЗГ-ын тогтоолтой нийцэж байна.
5	Хүчилтөрөгчийн хий, дагалдах сэлбэг хэрэгслийн хамт нийлүүлэх	Бараа	14,400.0	14,400.0	ЗГ-ын тогтоолтой нийцэж байна.
6	Пропаны хий, дагалдах сэлбэг хэрэгслийн хамт нийлүүлэх	Бараа	3,420.0	3,420.0	ЗГ-ын тогтоолтой нийцэж байна.
7	Хяналтын GPS төхөөрөмж 20ш нийлүүлэх	Бараа	19,890.0	19,890.0	ЗГ-ын тогтоолтой нийцэж байна.
8	ДХХА-н серверийн өрөөний №2-ын их засвар, агааржуулалтын хамт	Ажил	27,000.0	27,000.0	Өмнөх оноос дамжин хийгдэж буй ажилд нэмэлт санхүүжилт батлуулахдаа шууд гэрээний заалтанд оруулан батлуулж байгаа нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 8-р зүйл, МУ-ын

					ЗГазрын 2021 оны 05-р сарын 05-ны өдрийн 124 дүгээр тогтоолтой зөрчилдөж байна.
9	Зуух №1-н А-Б тээрмийн шалны савхан брон буюу түгжээ брон шинээр хийж, солих 206 ш	Ажил	19,900.0	19,900.0	ЗГ-ын тогтоолтой нийцэж байна.
10	Тавцант вагоны /платформ/-д их засвар хийх	Ажил	30,000.0	30,000.0	Улаанбаатар төмөр зам нь Илчит тэрэг эзэмшигч байгууллагтай засварын гэрээг шууд хийх тухай албан бичгийг ирүүлсэний дагуу шууд гэрээ байгуулсан байна. Хуульд нийцэхгүй шаардлага тавьсан нь ТБОНӨХБАҮХАТухай хуулийн 3-р зүйл, 3.4.Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.
11	ТЭМ-1285 Илчит тэрэгний 6 хос дугуйн их засвар	Ажил	94,000.0	94,000.0	Дараа онд шилжсэн.

⬇ Хуулийн хүрээнд худалдан авалтын төлөвлөгөөг зөв төлөвлөж байх.

5. Өмнөх онуудаас дамжин ирсэн ажлуудын гүйцэтгэл

2019 оноос хойш он дамжин хийгдэж буй 14 ажил 2022 онд дуусч гэрээ дүгнэсэн байна. Өмнөх оноос дамжин хийгдсэн ажлуудыг хүснэгтээр харуулав.

№	Он дамжсан ажлуудын нэр	Ажил эхэлсэн он	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээ дүгнүүлсэн хувь
1	ТГ 1.2 болон насосуудын удирдлагын хэлхээг компьютер, хяналт удирдлагын системд шилжүүлэх	2019	СПС ХХК	Гэрээний үүргээ дутуу биелүүлэн гэрээ дүгнүүлсэн
2	Турбин щитний дотор засвар хийх	2020	Эрдэнэт констрактив ХХК	100%
3	Мэдээллийн баазын сервер ТЭЗҮ программ хийх	2020	Лидер ХХК вишн	Гэрээний үүргээ дутуу биелүүлэн гэрээ дүгнүүлсэн

4	Турбин №1-ын их засварын ажил	2021	Эрчим маш ХХК	100%
5	Турбины насоснуудын удирдлагын компьютерийн хяналт мэдээллийн системд шилжүүлэх ажил	2021	Грийн электрик инженеринг ХХК	100%
6	Блок №1 /генератор. Трансформатор. 1ВА. 2ВА секцийн ажлын оруулга. Отбайк/-ын реле хамгаалалт. Автоматикийг микропроцессорын РХА-ийн төхөөрөмжөөр шинэчлэх	2021	Монхорус ХХК	100%
7	Техникийн усны нөөц шугам зураг барих ажлын зураг төсөв хийх	2021	Силвер Эделвэйз ХХК	100%
8	Өрлөг дулаалгын материал нийлүүлэх	2021	СММ ХХК	Гэрээний үүргээ дутуу биелүүлэн гэрээ дүгнүүлсэн
9	Насосны ажлын дугуй гол дагалдах хэрэгсэл нийлүүлэх	2021	Тано Эрдэнэ Трейд ХХК	100%
10	Илчит тэрэгний сэлбэг худалдан авах	2021	Айсуй хээр ХХК	100%
11	Тос тосолгооны материал худалдах худалдан авах	2021	НИК ХХК	100%
12	Пакеттай жүүс худалдах. Худалдан авах	2021	Катерер ХХК	100%
13	Зуух №1,2-р үеийн гаансын хамт шинээр солих ган труба нийлүүлэх	2021	Арвилах ХХК	100%
14	Ган труба. Лист худалдах худалдан авах	2021	Эй Жи Ар ХХК	100%

↓ Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлдэггүй аж ахуйн нэгж байгууллагатай дахин хамтран ажиллах гэрээ байгуулахгүй байх.

6. 2022 оноос дараа онд шилжиж буй ажлууд

Тайланд оноос дараа онд шилжин хийгдэж буй 11 ажил байна. Ажил тус бүрийг хүснэгтээр харуулав.

№	Он дамжсан ажлуудын нэр	Ажил эхэлсэн он	Гүйцэтгэгч байгууллага	Мөнгөн дүн /мян.төг/
1	Зуух №3-т их засвар хийх	2022	СММ ХХК	2,100,000.0
2	Цахилгаан хөдөлгүүр 4АМ-355М-6У3 /200 кВт/, Цахилгаан хөдөлгүүр 4А355М8У3 /160 кВт/, Цахилгаан хөдөлгүүр 4А3М-500/6000 УХЛА тус тус нийлүүлэх.	2022	"Бүж нар" ХХК	199,500.0
3	Өөрөө буулгагч авто машин /Hyundai HD270 Dump Truck/ нийлүүлэх	2022	"Хьюндай Моторс монгол"ХХК	345,000.0

4	Ган труба нийлүүлэх	2022	"Тано Эрдэнэ" ХХК	114,200.0
5	Зуух №3,4-ийн модуль контроллёр, программ хангамжийн шинэчилэлд шаардлагатай материал нийлүүлэх	2022	'Хэрлэнгийн боргио" ХХК	72,796.0
6	Тавцант вагоны /платформ/-д их засвар хийх	2022	Улаанбаатар төмөр зам	30,000.0
7	ТЭМ-1285 Илчит тэрэгний 6 хос дугуйн их засвар	2022		94,000.0

Хавсралт №2-р бусад шаардлагатай материалын жагсаалтыг харуулав.

Тендер шалгаруулалттай холбоотой 1 гомдол гарсан бөгөөд СЯаманд хянагдан дахин үнэлгээ хийх зөвлөмж ирсэн байна.

- ✦ 2023 онд шилжин хийгдэж буй бараа, ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэн богино хугацаанд хүлээн авах ажлыг зохион байгуулах.

Дүгнэлт:

Компаний хэмжээнд 2022 оны худалдан авах ажиллагаа бүрэн хийгдэж дууссан боловч худалдан авах ажиллагаагаар нийлүүлэгдэж буй бараа материалыг хүлээн авалт хангалтгүй байна.

Зөвлөмж:

1. Худалдан авах ажиллагаагаар нийлүүлэгдэж буй бараа материалыг хүлээн авах комиссыг байгуулж албан тушаалтнуудыг үүрэгжүүлэх.
2. Тодотголоор нэмэгдэж буй худалдан авалтуудийн үндэслэлийг нарийвчлан гаргаж байх.
3. Он дамжин хийгдэж буй ажлуудын гүйцэтгэлийг гэрээнд заасан хугацаанд гүйцэтгүүлэх.
4. Хуулийн хүрээнд худалдан авалтын төлөвлөгөөг зөв төлөвлөж байх.
5. Гэрээгээр хүлээсэн үүргээ бүрэн биелүүлдэггүй аж ахуйн нэгж байгууллагатай дахин хамтран ажиллах гэрээ байгуулахгүй байх.
6. 2023 онд шилжин хийгдэж буй бараа, ажил үйлчилгээг чанарын өндөр түвшинд гүйцэтгүүлэн богино хугацаанд хүлээн авах ажлыг зохион байгуулах.
7. Хуулийн хугацаанд тендерийн баримт бичиг, гэрээ, гэрээ дүгнэсэн актыг эмхлэн архивт хүлээлгэн өгөх.

Танилцсан:

Гүйцэтгэх захирал

Б.Бат-Эрдэнэ

Хянасан:

ДХХдарга

Б.Ганбат

Тайлан бичсэн:

Дотоод аудитор

С.Үнэнхүү